



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 677

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө баланаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр 1, 2, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 168 дуаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гаалийн ерөнхий газрын харьяа Горхи мэлхий хад амралтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 иж бүрдэл, нийт 10,812,500.00 (арван сая найман зуун арван хоёр мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ, бүхий хавсралтад заасан хөрөнгийг Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Эрхүү хотод суугаа Ерөнхий консулын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонбаатар, Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Эрхүү хотод суугаа Ерөнхий консул Ж.Энхжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

131-0000002

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
6.77... дугаар тогтоолын хавсралт

Гаалийн ерөнхий газрын харьяа Горхи мэлхий хад амралтын газрын
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Монгол Улсаас Оросын Холбооны Улсын
Эрхүү хотод суугаа Ерөнхий консулын газарт балансаас
балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Стандарт өрөөний иж бүрдэл	5 ком /иж бүрдэл/	2,162,500.00	10,812,500.00
	Нийт дүн			10,812,500.00 (арван сая найман зуун арван хоёр мянга таван зуун)